



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/489

Хэрлэн сум

Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3, 60.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны гуравдугаар хуралдааны 05 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг, дэмжлэг үзүүлэх “Нутгийн ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай 06 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Нутгийн ирээдүй” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2025-2026 оны хичээлийн жилд орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж буй нэр бүхий оюутнуудад сургалтын төлбөрийн 30, 273,700 (гучин сая хоёр зуун далан гурван мянга долоон зуу) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Суралцагчдын төлбөрийн мэдээллийн задаргааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 4.3.1.1. Орон нутагт хэрэгцээ шаардлагатай мэргэжлийн судалгаанд үндэслэн “Нутгийн ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлнэ зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмонд)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



Dr C / m

قصص

$\frac{20}{\text{بصر}}$ $\frac{20}{\text{بصر و}}$ $\frac{20}{\text{بصر (بصر)}}$

[illegible]